“Алтан үзэг” наадамд зориулан бүтээв.

ХИС-ийн оюутан Б.Халиунаа

Мартагдсан Монгол эрчүүд

Хүн төрөлхтөн бий болж, байгаль дэлхийтэй хүйн холбоогоор холбогдсон балар эртний үеэс эхлэн угсаатан аймгуудын дунд эхийн эрхт ёс болон эцгийн эрхт ёс ноёлж ирсэн. Харин Монгол улс эцгийн эрхт ёсыг дагаж, дээдэлж ирсэн нь МЭӨ хоёр мянган жилийн өмнөх үеэс үүдэлтэй. XX-р зууныг хүртэл эцгийн эрхт ёсыг сахин биелүүлж айл гэр, ард иргэд, улс орныг эр хүн толгойлж явсан нь үнэн. Ардын засгийн жилүүдэд Монголын эмэгтэйчүүд нийгмийн үр шимийг хангалттай амсаж, тэс өөр болтлоо хөгжин дэвшиж, нийгмийг түүчээлэн тэргүүлэх алдарт эмэгтэйчүүд гарж ирсэн нь XX-р зууны Монголын түүхэн ололтын нэгээхэн хэсэг гарцаагүй мөн. Харин энэхүү нийгмийн шинэчлэлийн давлагаа эрчүүдэд сайнаар бус харин ч халгаатай, харамсмаар үйл явдлууд тохиож, үүний үр шим одоогийн нийгэмд ч нөлөөлсөөр байна. 1932 оны “Эсэргүү болого”, Халхын голын дайн зэрэгт эрчүүд л явж амиа өргөсөн бол 1937 онд болсон “Төрийн террор” хэмээн нэрлэж орчин үеийн түүх бичлэгт бичигддэг коммунист хядлагад өртөгсдийн 99 хувь нь эрчүүд байсан юм. Мөн хүрээ хийдэд шавилан сууж, хийж бүтээх үйлсээс хол хөндий байгсдыг тэр чигээрээ эрчүүд зонхилж байсан нь гарцаагүй. 1990 онд “Цагаан морин жил”-ийн анхны ардчилсан хувьсгалын парламент байгуулагдаж, үйлдвэр комбинат, ажил мэргэжил устаж нийгэм-эдийн засгийн хос шилжилт гээч нийгмийн туршилтын гол золиосд Монгол эрчүүд голлон өртсөн. Энэ шилжилт эхэлмэгц Монголд жендер (хүйсийн тэгш байдал) хэмээх асуудал өнөөдрийг хүртэл эрчээ авсаар 34 дэх жилийнхээ нүүрийг үзэж байна.

Уг ёсондоо бол жендерийн эрх тэгш байдал гэдэг нь Монгол улсын “Жендерийн эрх тэгш байдлыг хангах” тухай хуульд “Эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд хувь нэмрээ оруулснаар жендерийг ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг хэлнэ” хэмээн тодорхойлсон байдаг. Харин сүүлийн хэдэн жилүүдэд Монголын нийгэмд жендер гэдэг зүйл зөвхөн эмэгтэйчүүдэд тулгамдсан асуудал мэт нийгмийн хэмжүүрийг тогтоогоод буй. Яг энэ үзэл суртлаар явсаар нөгөө талд эрчүүдийн байр суурь, үнэ цэн гэх чухал зүйл уруудсаар уруудсаар хамгийн доод цэгтээ хүрэхэд тун ойртсон байна.

Үүний дагуу МУИС-ийн жендер судлалын магистрант А.Оюун-Эрдэнэ “Энэ жилийн байдлаар гэхэд л эмэгтэйчүүд улс төрийн оролцооны хувиараа манай улс Азид нэгдүгээрт бичигдсэн гэх мэтчилэн сүүлийн жилүүдэд эмэгтэйчүүдийн оролцоон дээр суурилсан үзүүлэлт нэмэгдсээр байгаа. Харин нөгөөтээгүүр эрчүүд маш олон зүйлс дээр орхигдож буй нь үнэн. Жишээ нь сүүлийн хоёр жилд эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдийнхтэй харьцуулахад асар олон жилийн зөрүүтэй байгаа. Мөн боловсрол эзэмшилтийн хомсдол, сэтгэцийн эрүүл мэнд, амиа хорлолт, нас баралт зэрэгт эрчүүд маш их өртөх болсон. Үүний хамгийн гол шалтгаан бол нийгмийн зүгээс тэдэнд тулгадаг хэвшмэл ойлголт юм” хэмээн үзэл бодлоо илэрхийллээ.

“Үндэсний статикийн хороо”-ноос мэдээлснээр Монгол улсын нийт хүн амын 49 хувийг эрчүүд, 51 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг. “Дэлхийн жендерийн ялгаа 2024” тайланд манай улс хүйсийн харьцаагаараа 146 орноос 85-д эрэмбэлэгджээ. Харин бидний өнөөгийн нийгэмд эмэгтэйчүүд илүү давамгайлсан цаг үе ирсэн байна. Улсын хэмжээнд 2023 оны байдлаар их дээд сургуульд суралцаж, дээд боловсрол эзэмшиж буй залуусын 61 хувь нь эмэгтэйчүүд бол үлдсэн хэд нь эрчүүд. Ерөөсөө их, дээд, улсын, хувийн гэлтгүй нийт оюутны ихэнх хувь нь охид. Ангийн онц сурлагатнуудын эхэнд охид, эмэгтэйчүүд байдаг хэмээн МУИС-ийн Олон улсын харилцааны сургуульд 12 жил багшилсан багш өөрийн нийтлэлдээ дурдсан юм. Ингээд бодохоор Монгол эрчүүд ер нь хаана байна вэ? Дундаж наслалтыг авч үзвэл энэ оны байдлаар эмэгтэйчүүд 76.8, эрчүүд 67.6 байдаг. Үүний хооронд 9.2 жилийн наслалтын зөрүү байгаа юм. Мөн амиа хорлолтын 60 гаруй хувийг, нийт гэмт хэрэг үйлдэгсдийн 60 орчим хувийг эрчүүд дүүргэж байна. Үүгээр ч барахгүй 18-35 насны малчдын 88 хувийг нөгөө л эрчүүд. Их хотын гэмт хэрэг, хөдөө малын хулгай, шоронгийн хоригдлууд тэр чигтээ эрчүүдээс бүрдэж, тэдний хоосон үлдээсэн орон зайг эмэгтэйчүүд дүүргэж байна. Ажилтай, амьдралтай, карьертай бүсгүйчүүд байхад муу нэртэй, буцах хаяггүй болсон Монгол эрчүүд хэнд тэгтлээ хэрэгтэй вэ?

Хүүхдийн хүмүүжилд аав, ээжийн үүрэг, хариуцлага хамгийн чухал. Тэр дундаа эцгийн үүрэг оролцоо номер нэгт. Эр хүн хэнд хамгийн хэрэгтэй вэ гэвэл бяцхан үрсдээ, гэр бүлдээ. Охиддоо түших тулгуур нь, хүүдээ харж өсөх үлгэр дуурайлал болох нь тэдний хамгийн том гавьяа юм. Аавын нөмөр нөөлөг, хайр халамжийг хангалттай хүртэж чадаагүй би өнөөдрийг хүртэл нэг ч сэтгэл рүүгээ өнгийж хараагүй байснаа анзаарсан юм. Аав гэдэг сэдэв эхлэхэд л, дуу явахад л одоо ч нулимсаа залгин суудгаа нуух юун. Эсрэг хүйстэнтэй харилцах харилцааны асуудал, өөртөө итгэлгүй байдал, бусдаас хайр халамж горьддог, бүх зүйлийн үүрэг, хариуцлагыг өөр дээрээ тохдог ээжийгээ л харж өссөн гэх мэт далд ухамсарт минь тогтсон ухамсрыг эргээгээд тунгаан бодоход аавын орон зай дутагдаж байгааг бага ч гэсэн анзаарах болсон минь энэ. Яг надтай адил эцэггүйдлийн улмаас сэтгэл зүйн олон асуудлыг дотроо хуримтлуулан явдаг мянга мянган хүүхэд, залуучууд байдаг нь гарцаагүй. Аавтай болон аавгүй өссөн хүүхдүүдийн сэтгэл зүйн ялгааны талаар “Шинэ эхлэл” ТББ-ын сэтгэл зүйч Б.Батчимэг “Аавын нөмөр, нөөлөг дор өссөн хүүхдүүдийн хувьд өөрийнхөө үнэ цэн болон өөртөө итгэлтэй байдлаараа эцгийн оролцоогүй өссөн хүүхдүүдээс илүү байдаг” хэмээн хэлсэн юм.

“Гэр бүл анхаарлын төвд” ТББ-ийн захирал, мастер багш Ч.Гансүх

Манай байгууллага 2014 оноос хойш гэр бүлд хандсан контент, олон улсын сургалт үйл ажиллагаа болон гэр бүлийн гишүүдэд сэтгэл зүйн боловсрол олгох, тэр дундаа аавуудад чиглэсэн, эрэгтэйчүүдийг боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Энэ хугацаанд бидний зүгээс харахад манайд аавууд гэхээсээ илүү ээжүүд маш их ханддаг. Ер нь манайх гэлтгүй ерөнхийд нь өөрийнхөө зүгээс харахад эрүүлжүүлэхийн 90 хувийг эрчүүд, хувь хүний хөгжлийн сургалт, цуглааны 90 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг. Ингээд харахаар эрчүүд маш их зүйл дээр өөрсдийгөө золиосолдог. Хүүхэд хүмүүжлийн тал дээр бол аав, ээжийн оролцоо хоёулаа чухал үүрэг гүйцэтгэдэг. Ээж хүүхдээ илүү хамгаалах байр суурьтай байдаг бол эцэг хүн илүү хүүхдийн бие даах тал дээр ажиллаж чаддаг. Олон

жилийн туршлагаас харахад муу аав гэж байдаггүй. Үнэн хэрэгтээ сайн аав байх арга барилаа олдоггүй аав нар гэж байдаг.

“Хүүхдүүд ид шидийн орныг гэртээ очоод аав, ээжээсээ мэдрээсэй гэж хүсдэг. Үүний төлөө л би энэ ажлыг хийж байгаа”

Ч.Гансүх

Сайн аав нар бий болбоос аз жаргалтай, гэгээлэг нийгэм үүсэхийн нэгээхэн хэсэг болж чадах юм. Харин тэднийг бүтээхийн тулд нийгэмд тогтсон хэвшмэл ойлголтыг танаж, эрчүүдийг боловсруулж чадавхжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зөв. Нэгэн жишээ дурдахад Сингапур улсад хар тамхины хэргээр таван удаа шоронгийн хаалга татсан залууг хоёр цагийн турш охинтой нь уулзуулж хамт байлгасны дараа охин нь явахгүй гэж уйлахыг харсан эцэг хүн тэрхэн мөчид л хаана юу хийж яваагаа ухаарч чадсан гэдэг. Энэ нь харин улсын бодлогоор хоригдлуудад хандаж явуулсан үйл ажиллагааны нэг байжээ. Энэ мэтчилэн Монгол аавуудыг чадавхжуулж, ганц бие ээжүүд бус элэг бүтэн гэр бүлүүд бий болоход жаргалтай ард иргэд бий болж, ирээдүйн чанартай хойч үе бүтээгдэх боломж нэмэгдсээр байх юм. Харин хүүхэд хүмүүжлийн хамгийн чухал нөлөө болох боловсролын салбарт ажиллагсдын 78 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг. Цэцэрлэгийн багш гэхэд л 95 хувь, ЕБС-ийн 80 хувь, их дээд сургуульд 62 хувийг, сургалт үйлдвэрлэлийн 62 хувийг эмэгтэй багш нар эзэлж байна. Эцэг хүн байхгүй бол ирээдүй хойч үеийг хэн хүмүүжүүлэх вэ? Тэдэнд “аав” хэрэгтэй.